



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өлзийтмандал эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/136/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дундговь аймаг

2025 он

Утас: 70592439

Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ

Утас: 70592225

Цахим хаяг: [Oyun-erdenet@audit.gov.mn](mailto:Oyun-erdenet@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Ихбаяр

Утас: 70593113

Цахим хаяг: [Ikhbayard@audit.gov.mn](mailto:Ikhbayard@audit.gov.mn)

Аудитор Л.Баянмөнх

Утас: 99997540

Цахим хаяг: [bayanmunkhamina@gmail.com](mailto:bayanmunkhamina@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ МАНДАЛ ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Т.УРАНГОО ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн “Өлзийт мандал” өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад нийт зардал өмнөх оноос 1.6 дахин буюу 228.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд албан хаагчдын цалин нэмэгдсэн, бараа, ажил, үйлчилгээний үнэ өссөнтэй тус тус холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

#### Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

#### Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дундговь аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилт 43 арга хэмжээг хэрэгжүүлж, 92.0 хувьтай үнэлэгдсэн байна.

4825020157

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>181,075,334.58</u></b>	<b><u>121,384,959.10</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	130,339,308.55	68,213,144.09
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	130,339,308.55	68,213,144.09
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	130,339,308.55	68,213,144.09
31211	Төрийн сангийн харилцах	130,339,308.55	68,213,144.09
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	12,660,492.00	33,668,435.70
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	12,660,492.00	33,668,435.70
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	165,000.00	5,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	165,000.00	5,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	38,075,534.03	19,503,379.31
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	13,032,594.46	14,559,406.54
35110	Тусгай зориулалттай материал	7,934,793.86	7,967,150.82
35130	Эм боох материал	5,097,800.60	6,592,255.72
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	25,042,939.57	4,943,972.77
35410	Бичиг хэргийн материал	303,500.00	266,500.00
35420	Аж ахуйн материал	24,524,366.80	4,527,450.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	150,000.00
35440	Түлш, шатах тослох материал	215,072.77	22.77
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,233,475,866.63	1,246,608,685.19
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,233,475,866.63	1,246,608,685.19
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,233,475,866.63	1,246,608,685.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,074,626,825.90	1,149,597,970.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,637,612.07)	-29,753,503.15)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,000,000.00	35,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,472,222.24)	-15,305,555.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	153,088,392.02	152,328,397.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	-40,056,908.16)	-69,617,186.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,603,843.14	32,841,835.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,476,451.96)	-13,283,273.86)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4,800,000.00	4,800,000.00
39301	Програм хангамж	113,003.00	113,003.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-113003.00	-113003.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4800000.00	4800000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1414551201.21</u></b>	<b><u>1367993644.29</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>479145.47</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	479145.47	0.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	479145.47	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	479145.47	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1414072055.74</u></b>	<b><u>1367993644.29</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,414,072,055.74	1,367,993,644.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	212,857,793.07	212,857,793.07
51101	Өмч: - төрийн	212,857,793.07	212,857,793.07
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,184,578,767.66	1,138,500,356.21
51210	Өмнөх үеийн үр дүн	186,283,446.00	1,184,578,767.66
51220	Тайлант үеийн үр дүн	998,295,321.66	(46,078,411.45)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,635,495.01	16,635,495.01
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,414,551,201.21</u></b>	<b><u>1,367,993,644.29</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>397,651,470.31</b>	<b>625,567,940.41</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>78,448,899.61</b>	<b>122,698,611.47</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	78,448,899.61	122,698,611.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,000,000.00	400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	400,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	37,645,338.73	78,094,745.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	37,803,560.88	44,203,866.47
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>319,202,570.70</b>	<b>502,869,328.94</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	8,186,545.20	18,974,128.97
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	8,186,545.20	18,974,128.97
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	-
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	311,016,025.50	483,895,199.97
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	311,016,025.50	483,895,199.97
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>330,358,885.75</b>	<b>671,646,351.86</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>330,358,885.75</b>	<b>671,646,351.86</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	329,908,885.75	669,633,251.86
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	190,740,253.00	391,784,248.97
210101	Үндсэн цалин	133,628,918.00	252,419,709.97
210102	Нэмэгдэл	22,654,430.00	55,628,709.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,961,000.00	13,078,000.00
210104	Урамшуулал	28,495,905.00	70,657,830.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,435,968.50	50,665,941.60
210201	Тэтгэврийн даатгал	23,435,968.50	50,665,941.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,401,799.63	20,986,350.86
210301	Гэрэл, цахилгаан	572,510.63	1,605,816.86
210302	Түлш, халаалт	5,518,529.00	18,147,654.00
210303	Цэвэр, бохир ус	310,760.00	1,232,880.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,163,192.78	49,695,425.80
210401	Бичиг хэрэг	18,607,584.00	2,921,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,221,947.00	2,397,782.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,090,100.00	1,245,697.00
210404	Ном, хэвлэл	-	20,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,896,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,243,561.78	40,214,146.80
210408	Бараа материал акталсны зардал	-	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,869,115.66	61,195,881.29
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,669,115.66	61,195,881.29
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	706,450.00	3,910,250.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	706,450.00	3,910,250.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,030,000.00	4,653,700.00
210702	Дотоод албан томилолт	4,030,000.00	4,653,700.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,625,472.80	7,596,505.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,204,267.00	6,323,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	254,250.00	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	29,132.80	25,132.80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	32,723.00	32,723.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	75,100.00	103,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	42,936,633.38	79,144,947.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,825,352.50	11,483,021.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,111,280.88	67,661,926.44
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	450,000.00	2,013,100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	450,000.00	2,013,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	450,000.00	2,013,100.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>67,292,584.56</b>	<b>(46,078,411.45)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	54,574.08	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	54,574.08	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(54,574.08)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>67,238,010.48</b>	<b>(46,078,411.45)</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>322,202,570.70</b>	<b>482,101,385.24</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,000,000.00</b>	<b>400,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,000,000.00	400,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,000,000.00	400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	400,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>319,202,570.70</b>	<b>481,701,385.24</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	8,186,545.20	18,974,128.97
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	8,186,545.20	18,974,128.97
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	311,016,025.50	462,727,256.27
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	311,016,025.50	462,727,256.27
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>461,837,574.05</b>	<b>541,527,549.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>461,837,574.05</b>	<b>541,527,549.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>461,052,574.05</b>	<b>539,514,449.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	275,757,881.42	395,682,410.87
210101	Үндсэн цалин	169,509,859.08	256,492,682.87
210102	Нэмэгдэл	45,027,177.34	55,628,709.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,043,000.00	13,078,000.00
210104	Урамшуулал	53,177,845.00	70,483,019.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,421,465.45	47,246,925.17
210201	Тэтгэврийн даатгал	32,170,078.45	47,246,925.17
210202	Тэтгэмжийн даатгал	251,387.00	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,458,660.81	20,986,350.86
210301	Гэрэл, цахилгаан	761,091.81	1,605,816.86

210302	Түлш, халаалт	12,158,349.00	18,147,654.00
210303	Цэвэр, бохир ус	539,220.00	1,232,880.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>47,074,152.77</b>	<b>25,150,304.00</b>
210401	Бичиг хэрэг	19,403,550.00	3,126,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,016,642.77	2,182,732.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,538,900.00	1,245,697.00
210404	Ном, хэвлэл	-	20,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,066,860.00	2,896,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,048,200.00	15,679,075.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>20,983,404.00</b>	<b>26,076,363.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,763,404.00	23,896,363.00
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,220,000.00	2,180,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>39,949,150.00</b>	<b>6,083,050.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,539,000.00	-
210602	Тавилга	18,900,000.00	-
210604	Урсгал засвар	10,510,150.00	6,083,050.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,191,400.00</b>	<b>4,653,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,191,400.00	4,653,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,442,359.60</b>	<b>7,596,505.80</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,992,021.00	6,323,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	254,250.00	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58,265.60	25,132.80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	32,723.00	32,723.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	75,100.00	103,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,774,100.00</b>	<b>6,038,840.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,774,100.00	6,038,840.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>785,000.00</b>	<b>2,013,100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>785,000.00</b>	<b>2,013,100.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	785,000.00	2,013,100.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>(139,635,003.35)</u></b>	<b><u>(59,426,164.46)</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,110,000.00</b>	<b>2,700,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,110,000.00</b>	<b>2,700,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,110,000.00</b>	<b>2,700,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,110,000.00	2,700,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(6,110,000.00)</u></b>	<b><u>(2,700,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(145,745,003.35)</b>	<b>(62,126,164.46)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>162,289,227.00</b>	<b>130,339,308.55</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>16,544,223.65</b>	<b>68,213,144.09</b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,857,793.07	16,635,495.01	186,283,446.00	415,776,734.08
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,857,793.07	16,635,495.01	186,283,446.00	415,776,734.08
5	Тайлант үеийн үр дүн	-	-	998,295,321.66	998,295,321.66
6	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,857,793.07	16,635,495.01	1,184,578,767.66	1,414,072,055.74
7	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	212,857,793.07	16,635,495.01	1,184,578,767.66	1,414,072,055.74
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,857,793.07	16,635,495.01	1,184,578,767.66	1,414,072,055.74
11	Тайлант үеийн үр дүн	-	-	-46,078,411.45	-46,078,411.45
12	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,857,793.07	16,635,495.01	1,138,500,356.21	1,367,993,644.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		130,339,308.55
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	633,608,637.49	544,227,549.70
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	633,608,637.49	544,227,549.70
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	631,595,537.49	542,214,449.70
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	484,220,037.49	395,682,410.87
210101	Үндсэн цалин	342,490,037.49	256,492,682.87
210102	Нэмэгдэл	55,630,000.00	55,628,709.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,100,000.00	13,078,000.00
210104	Урамшуулал	73,000,000.00	70,483,019.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	48,000,000.00	47,246,925.17
210201	Тэтгэврийн даатгал	48,000,000.00	47,246,925.17
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,996,000.00	20,986,350.86
210301	Гэрэл, цахилгаан	1,606,000.00	1,605,816.86
210302	Түлш, халаалт	18,150,000.00	18,147,654.00
210303	Цэвэр, бохир ус	1,240,000.00	1,232,880.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,196,000.00	25,150,304.00
210401	Бичиг хэрэг	3,130,000.00	3,126,800.00

210402	Тээвэр, шатахуун	2,200,000.00	2,182,732.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,250,000.00	1,245,697.00
210404	Ном хэвлэл	20,000.00	20,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,896,000.00	2,896,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,700,000.00	15,679,075.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>26,080,000.00</b>	<b>26,076,363.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,900,000.00	23,896,363.00
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,180,000.00	2,180,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,800,000.00</b>	<b>8,783,050.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,700,000.00	2,700,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	6,100,000.00	6,083,050.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,660,000.00</b>	<b>4,653,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,660,000.00	4,653,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,604,500.00</b>	<b>7,596,505.80</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,330,000.00	6,323,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	74,300.00	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	26,000.00	25,132.80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	33,000.00	32,723.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	103,200.00	103,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,039,000.00</b>	<b>6,038,840.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,039,000.00	6,038,840.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,013,100.00</b>	<b>2,013,100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>-</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,013,100.00	2,013,100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>633,608,637.49</b>	
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>18,974,128.97</b>	<b>18,307,550.00</b>
122005	Орон нутгийн төсвөөс	18,974,128.97	18,307,550.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>400,000.00</b>	<b>400,000.00</b>
120010	Туслах үйл ажиллагааны орлого	400,000.00	400,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	130,339,308.55	
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>483,895,199.97</b>	<b>463,393,835.24</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	483,895,199.97	463,393,835.24
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>130,339,308.55</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>68,213,144.09</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>

610001	Төсвийн байгууллага	0.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	1.00	0.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>14.00</b>	<b>14.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,013.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад залруулсан алдаа байхгүй, 900.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 113.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

#### *Залруулагдаагүй алдаа:*

Аудитаар нийт 2,013.0 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч 900.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 113.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүллээ.

#### 3.1 Төлбөрийн акт

##### 3.1.1. Зардлын данстай холбоотой

##### *Илрүүлэлт:*

Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа нягтлан бодогчид санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр үндсэн байгууллагатай нь давхардуулан урамшуулал олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т /Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:/ 15.1.3-т /хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;/ Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 -т /Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна/ гэж заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 3.2 Албан шаардлага

##### 3.2.1 Зардлын данстай холбоотой

##### *Илрүүлэлт:*

Байгууллагын нярвын ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч албан тушаалтын тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшуулал давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т /Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:/ 15.1.3-т /хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;/ Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т /Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна/ гэж заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 3.3 Зөвлөмж

##### 3.3.1 Бараа материалын данстай холбоотой

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 4 нэр төрлийн үндсэн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ аваагүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-д заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д: "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-д заасныг, мөн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийн талаар холбогдох эрх бүхий байгууллагад саналаа хүргүүлж шийдвэрлүүлэх, хариуг 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа нягтлан бодогчид санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр үндсэн байгууллагатай нь давхардуулан урамшуулал олгосон	1	900.0	1	900.0						
Байгууллагын нярвын ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч албан тушаалтын тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшуулал давхардуулан олгосон	1	1,000.0			1	1,000.0				
Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 4 нэр төрлийн үндсэн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ аваагүй	1	113.0					1	113.0		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>2,013.0</b>	<b>1</b>	<b>900.0</b>	<b>1</b>	<b>1,000.0</b>	<b>1</b>	<b>113.0</b>	<b>-</b>	<b>-</b>

#### 5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				

A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			